

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх (цаашид “тангараг өргөх” гэх) ёслолыг зохион байгуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Монгол Улсын иргэн төрийн захиргааны албан тушаалд анх удаа, хууль ёсны дагуу, жинхлэн томилогдсоноор төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх эрх үүснэ.

1.3.Тангараг өргөх ёслолын арга хэмжээг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулна.

Хоёр.Тангараг өргөх ёслолын арга хэмжээний зохион байгуулалт

2.1.Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын арга хэмжээг Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөл, тухайн байгууллага удирдан зохион байгуулна.

2.2.Тангараг өргүүлэх арга хэмжээг хариуцан зохион байгуулах албан тушаалтныг энэ журмын 2.1-т заасан байгууллагын даргын шийдвэрээр томилж, хугацаа, хөтөлбөрийг батална.

2.3.Энэ журмын 1.2-т заасан эрх үүссэн тангараг өргөх албан хаагчдын нэрийг тухайн байгууллагын даргын тушаалаар батална.

2.4.Тангараг өргөх ёслолын арга хэмжээнд тухайн байгууллагын удирдах албан тушаалтан, хамт олон, олон нийтийн төлөөллийг оролцуулна.

2.5.Тангараг өргөх ёслолын арга хэмжээ зохион байгуулах газарт Монгол Улсын төрийн сүлд, төрийн далбааг хууль тогтоомжид заасны дагуу байрлуулна.

2.6.Тангаргийн хуудсыг батлагдсан загварын дагуу тангараг өргөгчийн тоогоор хэвлэн, албан хаагчийн гарын үсэг зурах үзэгтэй хамт тусгайлан бэлтгэсэн байна.

2.7.Албан хаагч нь тангараг өргөхдөө албаны, дүрэмт, эсхүл үндэсний хувцастай байна.

2.8.Энэ журмын 2.2-т заасны дагуу томилогдсон албан тушаалтан тангараг өргүүлэх тухай шийдвэрийг уншиж, тангараг өргөх албан хаагч, ёслолын арга хэмжээнд оролцогчдыг танилцуулна.

2.9.Тангараг өргөх албан хаагчийн нэрийг цагаан толгойн үсгийн дарааллаар жагсаана.

2.10.Тангараг өргөгч нь “Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, Монгол Улсын хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая. Тангаргаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ” хэмээн тангаргийг цээжээр, тод, чанга, хүндэтгэлтэй дуудна.

2.11.Тангаргийг дуудаж дууссаны дараа төрийн сүлдэнд мэхийн ёсолж, Төрийн далбааны өмнө баруун өвдөг мэхийн сууж адис авч, тангаргийн хуудаст гарын үсэг зурна.

2.12.Албан хаагч нь тангаргийн хуудсанд гарын үсэг зурсаны дараа ёслолын арга хэмжээг удирдаж буй албан тушаалтан тамга, тэмдэг дарж баталгаажуулна.

2.13.Тангараг өргөх ёслолын арга хэмжээнд оролцож байгаа байгууллагын дарга албан хаагчид баяр хүргэж, үг хэлсний дараа Монгол Улсын төрийн дууллыг эгшиглүүлснээр ёслолын арга хэмжээ өндөрлөнө.

2.14.Тангараг өргөх ёслолын арга хэмжээний үед оролцогчид босож хүндэтгэл үзүүлнэ.

Гурав.Тангаргийн хуудас

3.1.Тангаргийн хуудас нь төрийн албан хаагчийг төрийн албанд хууль дээдлэн, шударга, мэргэшин ажиллахыг илтгэсэн баталгаажуулалтын нотлох баримт болно.

3.2.Тангаргийн хуудасны загварыг Төрийн албаны зөвлөл батална.

3.3.Тангаргийн хуудас нь нэгдсэн дугаар, тусгайлсан нууцлалтай байна. Дугаарыг давхардуулж, алгасуулан олгохгүй.

3.4.Тангаргийн хуудасны бүртгэлийг Төрийн албаны зөвлөл хөтөлж, дугаар олгоно.

3.5.Тангаргийн хуудас нь 1 хувь үнэт цаасан дээр үйлдэгдэнэ. Үнэт цаасан дээр хэвлэгдсэн эх хувийг тангараг өргүүлэх шийдвэрийн хамт албан хаагчийн хувийн хэрэгт хадгална.

3.6.Тангаргийн хуудсыг хувилж албан хаагчид хадгалуулна.

Дөрөв.Бусад зүйл

4.1.Хүндэтгэн үзэх зайлшгүй шалтгаан (хүндээр өвчилсөн, ар гэрт нь гачигдал гарсан, нийтийг хамарсан дайчилгаанд хамрагдсан, хорио цээрийн дэглэм тогтоогдсон, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг тохиолдсон)-ны улмаас энэ журмын 2.2-т заасан хугацаанд тангараг өргүүлэх ажлыг зохион байгуулах боломжгүй болсон тохиолдолд тангараг өргөх албан хаагчдад мэдэгдэнэ.

4.2.Төрийн албаны тухай хуульд заасны дагуу туршилтын хугацаагаар томилсон албан хаагчийг туршилтын хугацаа дуусахаас өмнө тангараг өргүүлэхийг хориглоно. Туршилтын хугацаа дуусаж, тухайн албан тушаалд томилох шийдвэр гаргасан тохиолдолд энэхүү журамд заасны дагуу тангараг өргүүлнэ.

4.3.Төрийн захиргааны байгууллага нь “Төрийн жинхэнэ албаны тангараг”-ийг хүндэтгэлийн болон хурлын танхимд байрлуулна.

4.4.Энэ журмын хэрэгжилтэд Төрийн албаны зөвлөл хяналт тавьж ажиллана.

Тав.Тангаргийг хүчингүйд тооцох, хариуцлага

5.1.Албан хаагчийг төрийн жинхэнэ албан тушаалд хууль бусаар томилсныг эрх бүхий байгууллага тогтоосон бол тангараг өргүүлсэн шийдвэр, тангаргийн хуудсыг шийдвэр гаргасан албан тушаалтан хүчингүй болгож, Төрийн албаны зөвлөлд ирүүлнэ. Төрийн албаны зөвлөл тангаргийн хуудасны дугаарыг хүчингүй болгон нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

5.2.Энэ журмыг зөрчсөн албан тушаалтан, албан хаагчид Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oO---